



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/Б1

Мандалговь

“Сар шинэ” нэгдсэн арга хэмжээ зохион
байгуулах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 в, Цагдаагийн албаны тухай хуулийн 65 дугаар 65.5, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлан гаргасан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5, Засаг даргын зөвлөлийн хурлын 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн хөдөлгөөнд тавих хяналт, шалгалтыг сайжруулах, аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй бусдын өмчийг хулгайлах, мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мал махны гарал үүслийн бичигт хяналт тавих хяналтыг эрчимжүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор “Сар шинэ-2019” нэгдсэн арга хэмжээг 14 хоногийн хугацаанд зохион байгуулах зардлыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Тус арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (О.Амарсанаа), аймгийн Автотээврийн үндэсний төв (Ц.Бямбацогт), Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн)-т даалгасугай.

Гурав. Дээрх арга хэмжээнд шаардагдах 2062840 (Хоёр сая жаран хоёр мянга найман зуун дөч) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190209

Аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын
28-ны өдрийн 1/81 дугаар захирамжийн хавсралт

АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН ТООЦОО

№	Төсөвт ажил	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт зардал
1	Бензин	226л	1840	415840
2	Хоол	174	6000	1044000
3	Байр	60	10000	600000
4	Нэгж	1	3000	3000
	Нийт дүн			2062840